



**ОРХОН АЙМАГ  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 02/35

Жаргалант сум

**Ойгоос 2026 онд бэлтгэх модны дээд  
хэмжээг тогтоох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсэг, Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 07 дугаар сарын 09-ны 03/38 дугаар тогтоолыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит IV хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1.Жаргалант сумын ойн сангаас 2026 онд бэлтгэх модны дээд хэмжээг ойн цэвэрлэгээний ажлаар хэрэглээний хуурай шинэс мод 100 шоо метр, түлээний шинэс мод 1000 шоо метр байхаар тус тус тогтоосугай.

2.Тус сумаас 2026 онд бэлтгэх түлшний модны нөөцийг мэргэжлийн байгууллагаар тогтоолгож, мод бэлтгэх талбайг тусгаарлуулахыг Засаг дарга (Л.Учрал)-д даалгасугай.

ДАРГА



Ш.БИЛГҮҮНБААТАР